



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2022.12.02 № 1013
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв эмнэлгүүдээс 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 6 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА



142204000782

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 394 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь өмнөх сараас бага зэргийн буурсан үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 84% /331/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн
хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо	
		4-6 хоног	7-с дээш хоног
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	3	81
2	Ерөнхий мэс засал	5	50
3	Хими	1	45
4	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	24	22
5	Зүрх судас судлал	23	14
6	Хөхний төв	1	31
7	Туяа		30
8	Толгой, хүзүүний мэс засал	3	24
9	Ангиографи	1	21
10	Цээжний хөндийн мэс засал	2	6
11	Элэг судлал		7
12	Ерөнхий хавдар судлал		1
	Нийт	63	331

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 84, Ерөнхий мэс засалд үзүүлэхээр үзлэгийн кабинетэд 55, Хими эмчилгээний үзлэгийн кабинетэд 46 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоног нийт 138 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 43, Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 39, ходоод дурандуулах болон хөхний зураг авахуулахаар тус бүр 18, эхо оношилгоо хийлгэхээр 14, рентгенд харуулахаар 6 үйлчлүүлэгч 4-с дээш хоногоор хүлээж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлтэй, нийт 332 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байна /Хүснэгт 2/.

Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо			
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	Нийт
1	Өдрийн хими	19	73	57	149
2	Хими	28	25	19	72
3	Ангиографи	8	14	9	31
4	Эмэгтэйчүүдийн мэс засал	13	5	3	21
5	Хөнгөвчлөх	2	6	7	15
6	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	7	6		13
7	Толгой, хүзүүний мэс засал	6	4		10
8	Дуран	5	3		8
9	Ерөнхий мэс засал	3	2	1	6
10	Хөхний төв	6	-	-	6
11	Цээжний хөндийн мэс засал	1	-	-	1
	Нийт	98	138	96	332

Тус эмнэлэгт өдрийн хими эмчилгээ хийлгэхээр нийт 149 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж буй үзүүлэлттэй байгаа боловч хавдартай үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлот хими эмчилгээ хийдэг нь хүлээгдэлтэй харагдахад нөлөөлдөг болно. Хими эмчилгээний тасагт хэвтэхээр 72, ангиографиийн тасагт хэвэхээр 31 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн тайлангаас харахад амбулаторийн тусламж, үйлчилгээ 2022 оны 10 сард хүлээгдэл багатай байна. Нүдний эмчид үзүүлэхээр 9, Хоол боловсруулах эрхтний эмчид үзүүлэхээр 4 үйлчлүүлэгч тус бүр 4-6 хоног, Чих хамар хоолойн эмчид үзүүлэхээр 5 үйлчлүүлэгч 7-с дээш хоног, Хэрх үе судлалын эмчид үзүүлэхээр 6 үйлчлүүлэгч 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Оношилгооны хувьд тус эмнэлгийн MRI-ийн оношилгооны хүлээгдэл маш их, 150 үйлчлүүлэгч 15-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай харьцуулахад харьцангуй буурсан үзүүлэлттэй байгаа боловч 2022 он дуустал эмчлүүлэгчдийг хүлээлгийн захиалганд бүртгэхгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1454 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь өмнөх сараас 320 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хамгийн их хүлээгдэлтэй 5 тасгийн мэдээллийг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Нүдний тасаг	3-6 хоног	16
		7-14 хоног	45
		15-30 хоног	44
		1 сараас дээш	450
	Нийт		555
2	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	18
		7-14 хоног	37
		15-30 хоног	150
		1 сараас дээш	325
	Нийт		530
3	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг	3-6 хоног	10
		7-14 хоног	21
		15-30 хоног	33
		1 сараас дээш	130
	Нийт		194
4	Бөөрний мэс заслын тасаг	3-6 хоног	30
		7-14хоног	25
		15-30 хоног	15
	Нийт		70
5	Мэс заслын тасаг	3-6 хоног	20
		7-14 хоног	15
		15-30 хоног	11
		1 сараас дээш	20
	Нийт		66

Нүдний тасагт хэвтэхээр нийт 555 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн дийлэнх буюу 81% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 530 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн талаас илүү буюу 61% нь удаан хугацаанд, мөн л 1 сараас дээш хугацаанд ор хүлээжээ. Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэхээр 194 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх орны хүлээгдэлтэй байна.

3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Нийт 115 үйлчлүүлэгч амбулаторийн 7 төрлийн кабинетийн эмчид үзүүлэхээр хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 20 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнээс хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	3 хоног	1
		4-6 хоног	2
		7-с дээш хоног	37
	Нийт		40
2	Мэдрэл судлал	3 хоног	1
		4-6 хоног	1
		7-с дээш хоног	19
	Нийт		21
3	Бөөр судлал	3 хоног	1
		7-с дээш хоног	18
	Нийт		19
4	Эмэгтэйчүүд судлал	3 хоног	1
		4-6 хоног	7
		7-с дээш хоног	7
	Нийт		15
5	Мэс засал судлал	4-6 хоног	2
		7-с дээш хоног	8
	Нийт		10
6	Уушиг судлал	4-6 хоног	9
	Нийт		9
7	Зүрх судас судлал	4-6 хоног	1
	Нийт		1
	БҮГД	3 хоног	4
		4-6 хоног	22
		7-с дээш хоног	89
НИЙТ		115	

Хүлээгдэлтэй байгаа үйлчлүүлэгчдийн дилэнх буюу 77% /89/ нь 7-с дээш хоног эмчд үзүүлэхээр хүлээж байна.

Эхо оношилгоо хийлгэхээр хамгийн их буюу нийт 22 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 19 нь 15-с дээш хоногоор хүлээгдэлтэй байна. Мөн рентген зураг авахуулахаар 16 үйлчлүүлэгч, MRI/CT хийлгэхээр 18 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлэгт лабораторийн шинжилгээ хийлгэхээр нийт 45 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаагийн тал нь орчим хувь нь /29/ биохимийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байна. Эдгээр 29 үйлчлүүлэгчийн 24 нь 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Орны хүлээгдлийн хувьд авч үзвэл, тус эмнэлгийн Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй байна. Уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 115 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 5/.

**Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэс засал судлал	3-6 хоног	56
		7-14 хоног	27
		15-30 хоног	32
	Нийт		115
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	15
		7-14 хоног	27
		15-30 хоног	12
	Нийт		54
3	Зүрх судасны тасаг	3-6 хоног	25
		7-14 хоног	13
		15-30 хоног	11
	Нийт		49
4	Чих, хамар, хоолой судлал	3-6 хоног	5
		7-14 хоног	10
		15-30 хоног	15
		1 сараас дээш	16
	Нийт		46
5	Эмэгтэйчүүд судлалын тасаг	3-6 хоног	10
		7-14 хоног	17
		15-30 хоног	15
	Нийт		42
6	Уламжлалт анагаах ухааны эмчилгээний тасаг	3-6 хоног	10
		7-14 хоног	14
		15-30 хоног	12
	Нийт		36
7	Бөөрний мэс засал судлал	3-6 хоног	7
		7-14 хоног	5
	Нийт		12
8	Мэдрэлийн мэс засал судлал	3-6 хоног	3
		7-14 хоног	3
		15-30 хоног	3
	Нийт		9
9	Мэдрэл судлал	3-6 хоног	7
	Нийт		7
10	Бөөр судлал	3-6 хоног	6
	Нийт		6
11	Уушиг судлал	3-6 хоног	1
	Нийт		1
	БҮГД	3-6 хоног	145
		7-14 хоног	116
		15-30 хоног	100
		1 сараас дээш	16
	НИЙТ		377

Мэс засал хийлгэхээр 115 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн тал хувь нь /59/ 3-6 хоног хүлээж байна.

4. Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн зүр судасны эмчид үзүүлэхээр 53 үйлчлүүлэгч 3 хоног хүлээж байгаа ба амбулаторийн бусад чиглэлийн үзлэг, лаборатори болон оношилгооны тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 641 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сараас 200 гаруй үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Чих хамар хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 441, зүрхний мэс засал, судасны мэс заслын тасагт хэвтэхээр 91, мэдрэлийн мэс заслын тасагт эмчлүүлэхээр 75 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор тус тус ор хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн 95%-ийг эзэлж байна. / Хүснэгт 6/

Хүснэгт 6. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 3 тасгийн мэдээ

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	26
		7-14хоног	50
		15-30 хоног	165
		1 сараас дээш	200
		Нийт	441
2	Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасаг	3-6 хоног	10
		7-14хоног	11
		15-30 хоног	30
		1 сараас дээш	40
		Нийт	91
3	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	19
		7-14хоног	36
		15-30 хоног	15
		1 сараас дээш	5
		Нийт	75
	БҮГД		607 /95%/

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус төвийн амбулаторийн үзлэг хүлээгдэлгүй байна. Амьд эдийн шинжилгээ хийлгэхээр 12, Арьс харшлын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 13 үйлчлүүлэгч тус тус 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна.

6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв

Тус төв нь 11 сард хүлээгдэл ихтэй ажиллаж байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 130 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Мөн Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 724 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хүлээгдэлтэй байна.

7. Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв нь хүлээгдэлгүй ажиллаж байна.

8. ГССҮТ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газрууд болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.